



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЁМБО МЭДЭЭ

№193 /403/ 2022.10.27

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

Б.БАЯРМАГНАЙ: ИДЭВХТЭЙ ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН НЬ ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН САЛШГҮЙ НЭГ ХЭСЭГ

Батлан хамгаалах яамны харьяа байгууллагууд 2022-2023 оны сургуулийн жилийн нээлттэй тохиолдуулан "Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг бүх нийтийн хүртээл болгох, алба хаагчдын спортын ур чадварыг сорих, хөгжүүлэх зорилготой "Урлаг, Спортын өдөрлөг"-ийг энэ сарын 27-28 өдрүүдэд "Алдар" спорт хороонд зохион байгуулж байна.

Энэ жилийн тэмцээнийг БХЯ-ны харьяа "Алдар" спорт хороо, "Багабаян" Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ хамтран зохион байгуулж байгаа бөгөөд БХЯ-ны харьяа байгууллагуудын 16 багийн 250 гаруй тамирчин сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, дартс гэсэн дөрвөн төрлөөр хурд хүч, авхаалж, самбаагаа сорин өрсөлдөж аваргаа шалгаруулах юм.

Тэмцээний нээлтийн арга хэмжээнд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний жанжин штабын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй БХЯ, ЗХЖШ харьяа байгууллагуудын удирдлага, бие бүрэлдэхүүн оролцоо.



ГЭРЭЛ ЗУРГИЙГ Х.УНДАРМАА

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай өдөрлөгийг нээж хэлсэн үгэндээ, идэвхтэй дасгал хөдөлгөөн нь эрүүл амьдралын салшгүй нэг хэсэг төдийгүй хүний бие, сэтгэл зүйд эергээр нөлөөлж, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэхээс гадна сэтгэл хямрал, бухимдлыг арилгаж, аливаа өвчинд

өртөх эрсдэлийг бууруулж, урт наслахын үндэс болдгийг онцлоод жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг тус тэмцээнд идэвхтэй оролцож буй нийт баг тамирчид, багш, дасгалжуулагч, хөгжөөн дэмжигчдэд амжилт хүссэн юм. Мөн энэ үеэр 2022 онд улсын болон Олон Улсын чанартай тэмцээнд

амжилт гаргасан "Алдар" спорт хорооны баг тамирчид, Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын уран бүтээлчдийг алдаршуулсан бөгөөд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид ОУ-ын тэмцээнээс шагнал хүртсэн шилдэг уран бүтээлийн дээжсээ үзэгч олонд өргөн бариллаа.

Ө.НАСАНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 5	☁ -6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 36	☁ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,412	3,420
EUR 🇪🇺	3,415	3,430
CNY 🇨🇳	467.50	473
RUB 🇷🇺	52.80	53.20
JPY 🇯🇵	23.20	23.50
KRW 🇰🇷	2.45	2.48

ЗУРХАЙ



2022.10.27 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 2

**НАМРЫН АДАГ ЦАГААН
НОХОЙ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:

Хэл, ам, хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шингэх:

07.29-17.43

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Төрөхүй

Д.ГАНХУЯГ: ЦОЛНЫХОО ҮНЭ ЦЭНИЙГ ЭРХЭМЛЭЖ АЖИЛЛААРАЙ



ГЭРЭЛ ЗУРГИЙГ Х.УНДАРМАА

Цэргийн албаны тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн баталсан Цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журмыг үндэслэн Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар зарим алба хаагчдад албан тушаалын

зэрэглэлийн цолыг гардууллаа.

Тодруулбал, БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн хошууч С.Галбадрах, ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн багш хошууч Г.Батгэрэл нарт албан тушаалын

зэрэглэлийн дэд хурандаа, БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ аж ахуйн хэлтсийн зураг төслийн албаны дарга ахмад П.Очирбат, ҮБХИС-ийн Сонсогчийн батальоны ротын захирагч ахмад Г.Ганчулуун, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн багш Б.Эрдэнэбат нарт

албан тушаалын зэрэглэлийн хошууч, БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн Барилгын зураг төслийн инженер дэслэгч Э.Батнаран, Цэргийн төв эмнэлгийн мэдээгүйжүүлэг судлалын их эмч дэслэгч Ш.Бүд, эмнэлзүйн эмгэг судлалын эс судлаач дэслэгч Т.Туул, урьдчилан сэргийлэх, тандалт судалгааны тасгийн нүүр ам судлалын их эмч дэслэгч Н.Оюун-Эрдэнэ нарт албан тушаалын зэрэглэлийн ахлах дэслэгч цолыг тус тус олгосон бөгөөд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга хурандаа С.Ванчинхүү нар гардуулсан юм.

Энэ үеэр БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг хэлсэн үгэндээ "Цэргийн хүн мөрдэс, энгэр хоёроо харж явдаг хэмээх үг байдаг. Эрхэлсэн албандаа идэвх зүтгэлтэй байж, эх орныхоо төлөө өргөсөн тангарагтаа үнэнч зүтгэж, зүүсэн цолныхоо үнэ цэнийг ямагт эрхэмлэж, салбарынхаа нэр хүндийг өндөрт өргөж яваарай. Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье" гэв.

Х.УНДАРМАА

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 634,121,317

Эдгэрсэн

Нийт: 613,153,839

Нас барсан

Нийт: 6,587,579

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООС СЭРГИЙЛЭХЭД ХҮН БҮРИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА ЧУХАЛ



2021 оны байдлаар явганаар замын хөдөлгөөнд оролцож яваад зам тээврийн осолд өртөн, гэмтэж бэртсэн 1224, амь насаа алдсан 116 тохиолдол бүртгэгдсэн нь цаашид энэ төрлийн ажил арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах, анхаарах зайлшгүй шаардлагатай гэдгийг харуулж байна.

"Гар утас" арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл өгвөл?

-Тээврийн хэрэгсэл жолоодож явах үедээ гар утас болон түүнтэй ижил төстэй төхөөрөмж ашиглахыг замын хөдөлгөөний дүрмээр хориглосон байдаг. Сүүлийн үед жолооч нар тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа гар утас ашиглах зөрчил ихэссэнтэй холбоотой зам тээврийн осолд холбогдох, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийн хохирогч, холбогдогч болох тохиолдол эрс нэмэгдэж байна.

Иргэдийн хувьд явган ч бай, тээврийн хэрэгсэлтэй ч

бай замын хөдөлгөөнд оролцох үедээ мэдэгдлээ шалгах, утсаар ярих гэх мэт анхаарал сарниулах олон эрсдэлт алхмуудыг хийдэг. Товчхондоо энэ хугацаанд таны жолоодож яваа авто машин аюултай байдал үүсгээд явж байна гэсэн үг. Жишээлбэл 60 километр цагийн хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэл 4 секундэд 32 метр замыг туулсан байдаг. Энэ үед жолооч аюул саадыг олж харлаа ч тээврийн хэрэгсэл бүрэн зогсоох хүртэл самбаачлах хугацаа, замын гадаргуу, ачаа тээш, тоормосны системийн ажиллагаа зэргээс шалтгаалаад харилцан адилгүй замыг туулж байж бүрэн зогсдог. Иймээс л өөртөө болон бусдад аюултай байдал үүсгэж тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа гар утсаа оролдохгүй байх шаардлагатай байна.

Мөн явган зорчигчид зам хөндлөн гарахдаа утсаар ярих, гар утас болон түүнтэй ижил төстэй тоглоом, хэрэгсэл оролдож ширтэх, зохицуулагчийн шүглэйн чимээ, бусдын дуут дохио анхааруулгыг

сонсох боломжийг хязгаарласан чихэвч зүүх, ном сонин зэргийг унших нь зам тээврийн ослын хохирогч, холбогдогч болох томоохон нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

Ойрын үед иргэдийг талцуулсан, бухимдуулсан зам тээврийн ноцтой осол их гарч гарч байна энэ талаар тодруулбал?

-Зам тээврийн осол иргэдийн анхаарлын төвд орж ирж байгаа нь маш сайн хэрэг юм. Зам тээврийн ослоор жилд дунджаар 450-500 орчим хүн амь насаа алдаж 2500-2800 орчим хүн гэмтэж бэртэж хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдах тохиолдлууд бүртгэгддэг. Зөвхөн чиглэлийн байгууллага нь бус хүн бүр энэ сэдвийг ярьж, сэргийлж, буруутай нь тэмцэж байж бид энэ олон үхэл хагацал, аюул саадыг зайлуулж чадна. Учир нь энэ сэдэв бол хүн бүрд хамаатай асуудал шүү дээ хэмээсэн юм.

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны урьдчилан сэргийлэх олон нийттэй харилцах мэргэжилтэн цагдаагийн ахлах дэслэгч Д.Ганхуягаас дараах тодруулгыг авлаа.

Ойрын үед зохион байгуулагдаж байгаа ажил, арга хэмжээний талаар

Манай уншигчдад хуваалцаач?

-Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан тодорхой ажил, арга хэмжээг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал, "Явган хүний гарц" хэсэгчилсэн арга хэмжээг амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Одоо "Гар утас" арга хэмжээг өрнүүлж байна.

"ЦЭРГИЙН МАНЛАЙЛАЛ-LEADERSHIP" СЭДЭВТ СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



NATO-ийн Батлан байгууллагын хөгжлийн төвийн доктор Свэн, Бернанд, Гаррайс тэргүүтэй сургагч багш нарын баг, УБХИС-ийн Эдийн засаг, менежментийн тэнхимийн багш нартай хамтран "Цэргийн манлайлал" сургалтыг ЗХЖШ, Төрлийн командлалуудын ахлах офицер, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын офицер, ахлагч нарын төлөөлөлтэй энэ сарын 25, 26-ны өдрүүдэд УБХИС-ийг түшиглэн зохион байгууллаа.

МОНГОЛЫН ДУГУЙН СПОРТЫН ТҮҮХЭНД ДЭЭД АМЖИЛТЫГ ТОГТООВ



"Tour de Langkawi 2022" /UCI 2.pro/ "А" зэрэглэлийн Мөнгөл Улсаас БХЯ-ны харьяа "Алдар" спорт хороо, Үндэсний шигшээ багийн тамирчин,

Малайзын "Теренгану полигон" мэргэжлийн багийн тамирчин ОУХМ С.Жамбалжамц оролцож амжилттай уралджээ.

Тэрээр тус тэмцээнээс 2 медаль, UCI-ийн 40 оноог хүртсэний зэрэгцээ тэмцээнээ Азийн шилдэг дугуйчны "Цагаан цамц"-тай өндөрлүүлснээр дэлхийд чансаагаараа 160, Ази тивд 2 дугаар байрт эрэмбэлэгдэж Монгол Улсын дугуйн спортын түүхэн дээд амжилтыг үзүүлээ. Манай тамирчин нийт 35 орны 117 тамирчинтай хүч сорин өрсөлдөж найман өдөрт 1100 км замыг 25 цаг 56 минут 32 секундэд туулсан амжилтыг үзүүлсэн юм.

АХЛАХ АХЛАГЧИЙН БЯЦХАН ОХИНД ХЗЦК, ТХЦК, БИЦУГ-ЫН ХАМТ ОЛОН ХАНДИВ ӨРГӨЛӨӨ



өвчнөөр шаналж суухыг харсан эцэг эх хоёр нь хашаа байшин, автомашинаа зарж, цэргийн тэтгэврийн зээл авч бүх боломжоо ашигласан ч эмчилгээний зардал нь дутаад байгаа юм.

Эмчилгээний зардалд шаардагдах 100 гаруй сая төгрөгийн 50 хувийг нь зарж болох бүхнээ зарж бүрдүүлсэн бөгөөд үлдсэн хэсгийг сайхан сэтгэлт мөрдөст нэгт нөхөд, нутгийн зон олон, иргэдээсээ хүсээд байгаа юм.

Хамгийн сүүлийн мэдээллээр бяцхан охинд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын хамт олон 700 мянган төгрөг, Тусгай хүчний цэргийн командлалын хамт олон 400 мянган төгрөг, Барилга инженерийн цэргийн удирдах газрын хамт олон 650 мянган төгрөг хандивлаж, бяцхан охиныг хурдан эдгэхийг ерөөжээ.

Мөн Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Зэвсэгт хүчний 339, 340, 342 дугаар ангиудын барилгачин дайчид, Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн хоёр тусгай

салбарын хамт олон, цэргийн алба хаагч, иргэд сайхан сэтгэлээр тусламжийн гараа сунгаад байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн Баян-Овоо сум болон Налайх дүүргийн төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгж, иргэд, багш сурган хүмүүжүүлэгч нар, бяцхан сурагчид хандивын аянд нэгдээд байгаа юм.

Бяцхан охин ирэх сарын 3-ны өдөр эмчилгээндээ явах бөгөөд хайрт охиноо аюулт өвчнөөс ангижруулахын төлөө бүхнээ зориулан хичээж байгаа бэлтгэл ахлах ахлагч Ш.Баттүвшин, Э.Чинтунгалаг нарт Зэвсэгт хүчний мөрдэс нэгт нөхөд болон сайхан сэтгэлт иргэдээсээ чин сэтгэлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг уриалж байна. Өгөх нь авахаасаа илүү ерөөлтэй гэдэг. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!

Хандивын данс ХААН БАНК: 5779009614 / Ээж Э.Чинтунгалаг/ Харилцах утас: Аав Ш.Баттүвшин 91887525, ээж Э.Чинтунгалаг 90857525

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №11

ЗАВЖ

Хүн, мал амьтны хоёр уруулын нийлэх захын хэсгийг завж гэдэг. Түүнтэй төстэй зурлага монгол бичигт байдаг.

Са, Ша үсгийн үндсэн бүтцэд завж ордог. Цагаан толгойн хэсэгт тусгайлан үзэх болно.

Дармалаар:

Бичмэлээр:

